



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар

А/634.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн "б", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Мөнхбаян-Эрдэнэ" ХХК-ний хийж гүйцэтгэсэн Дуут сумын сургуулийн барилгын дээврийн засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Дөлбадрал -Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга

Гишүүд:

Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц хариуцсан гэрээт ажилтан

Г.Энхбадам -Дуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал

Б.Түмэнжаргал -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж -Аймгийн архивын тасгийн дарга

Б.Бямбажав - "Мөнхбаян-Эрдэнэ"ХХК-ний захирал

Zax A/634 Ch

02 02733


Нарийн бичгийн
дарга:

Б.Жамбалдорж

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн

2. “Мөнхбаян-Эрдэнэ” ХХК -ний хийж гүйцэтгэсэн ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн дотор багтаан захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН